

ГАМШИГТ ӨРТСӨН ХҮН АМД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ АСУУДАЛ

Гамшиг судлалын магистрант Б.Тэнгис, Ш.Болдбаатар (Ph.D)

Хураангуй

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд дэлхий нийтэд гамшгийн улмаас 700 гаруй мянган хүн амь насаа алдаж, 1.4 сая гаруй хүн гэмтэж бэртэн, 23 сая орчим хүн орон гэргүй болсон байна. 1.5 тэрбум гаруй хүн гамшигт ямар нэг байдлаар нэрвэгджээ. Нийт учруулсан хохирлын хэмжээ нь 1.3 их наяд ам.долларт хүрсэн бол Монгол Улсад ойролцоогоор 33 мянга орчим байгалийн аюулт үзэгдэл, осол тохиолдож, 2237 хүний амь нас эрсдэн, 12.1 сая мал хорогдож, нийт учруулсан шууд хохирлын хэмжээ 1 их наяд 70 тэрбум төгрөг буюу 600 орчим сая ам.долларт хүрчээ. Энэ хохирлын хэмжээ нь одоогийн зах зээлийн үнэлгээгээр орчин үеийн иж бүрэн тоногдсон 200 хүүхдийн цэцэрлэг 260 гаруйг барьж байгуулах хөрөнгө юм. Ийм учраас гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэж чадваас бид гамшгийн үед учрах аюул, ослоос бага эрсдэл хүлээнэ.

Түлхүүр үг: хэвлэл, мэдээлэл, телевиз, радио, хэвлэлийн ажилтан

Гамшгаас урьдчилан сэргийлэхэд зарцуулсан нэг доллар гамшгийн дараах гурван доллартай тэнцдэг гэж үздэг байсан бол эдүүгээ урьдчилан сэргийлэхэд зарцуулсан нэг доллар гамшгийн хор уршгийг арилгахад зарцуулах 7 доллартай тэнцэж байна.

Шинэчлэлийн цаг үе, үзэл баримтлалтай нийцүүлэн хүний эрх, эрх чөлөөг тууштай хангах, улмаар иргэдийн аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх нь хувь хүнийг гамшгийн мэдлэг, чадвартай болгох, өөрийгөө болон бусдыг аврах ажиллагаанд сургахын тулд гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааг өнөөдрийн цаг үетэй нь уялдуулан шинэчлэн сайжруулах, нөгөө талаас гамшгийн үеийн мэдээ, мэдээллийг сайжруулах, хүн амын дунд явуулах ухуулга, сурталчилгааны ажлын чиглэлээр энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Гамшигт өртсөн иргэд зайлшгүй шаардлагатай мэдээллийг байнга авч байх ёстойг санах хэрэгтэй. Мөн тэдэнд хор уршгийг арилгах арга хэмжээ, тусламжийг цаг тухайд нь үзүүлж байх ёстой байдаг.

Телевиз радиогийн сурвалжлагчид гамшигт өртсөн голомтын бүсэд байгаа болон түүний гадна байгаа хүн амд дамжуулах мэдээллийн төрлийг хүснэгт 1.2 –т үзүүлэв.

Хүснэгт 1. Телевиз, радиогоос гамшигт өртсөн голомтын бүсэд байгаа болон түүний гадна байгаа хүн амд хүргэх мэдээллийн төрөл²¹

Гамшгийн үе шат мөчлөг	Гамшигт нэрвэгдсэн бүс нутгийн хүн ам	Гамшигт нэрвэгдэгдээгүй бүс нутгийн хүн ам
Гамшгийн аюул тулгарах өмнөх үед	Хувь хүн : -Нүүрлэж буй гамшгийн аюулын тухай төсөөлөлтэй байх -Нөөц бүрдүүлэх -Онцгой үед биеэ хэрхэн авч явах талаар мэдлэгтэй байх Олон нийт : Гамшгаас сэргийлэх арга хэмжээний нэн тэргүүлэх ач холбогдол шийдвэр гаргах - Гамшгийн үйл явцад хяналт тавихад иргэдийн оролцоог хангах	Хөнөөлийн гаднах иргэдийн тусламж: - Тусламж үзүүлэх хувь хүний санаачлага - Хандив тусламж үзүүлэх санаачлага Олон нийт: Олон нийтийн санаа бодлыг зөв чиглүүлж , тэдгээрийн оролцоо нэмэгдүүлэх
Гамшгийн үед	-Сэрэмжлүүлэх болон анхааруулах мэдээ дамжуулах - гамшгийн үед хэрхэн ажиллах тухай зөвлөмж хүргүүлэх	Олон нийт: -тусламж үзүүлэх компани т ажилд мөнгөн тусламж үзүүлэх
Гамшгийн дараахи үед	Хувь хүн: -тусламжийн арга хэмжээний тухай мэдээлэл дамжуулах Олон нийт: -алдаа дутагдлын тайлбарлах -Гамшгийн сургамжаас суралцах	Гамшгаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах арга хэмжээний нэн тэргүүний ач холбогдол

²¹ <https://www.academia.edu/8070343/role> of media in disaster management

Гамшигт нэрвэгдсэн хүн ам ямар нэгэн мэдээллээр хангагдаж чадаагүй, эсвэл худал мэдээлэл өгсөн нөхцөлд гамшгаас хамгаалах удирдлагад үйл ажиллагааг зохицуулахад бэрхшээлтэй асуудлууд үүсч гардаг.²²

Хэдийгээр гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг сайн төлөвлөж хэрэгжүүлэх боломжтой боловч тухайн үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж дараах тулгамдсан асуудлууд үүсч болзошгүй байдаг. Мөн гамшгийн хор уршгийг арилгах бэлэн байдлыг хангах арга хэмжээнд нэгэн адил хамаарна. Үүнд:

- Тодорхой баримтлах бодлого дутагдах;
- Зохион байгуулалт хангалтгүй байх;
- Төлөвлөлтийг буруу хийх.

Түүнчлэн бэлэн байдал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байх, зарлан мэдээллийг цаг хугацаанд нь явуулахгүй байх, хөнөөл уршгийг арилгах үйл ажиллагаа удаашралтай явагдах, хүнд нөхцөл, хямралт байдал нөлөөлөх, учирсан хөнөөл уршиг, хохирлыг үнэлэх, хяналт тавихад бэрхшээл үүсэх, ажиглалт хяналтаас буруу мэдээ ирүүлэх, хүн ам, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн давхцах, мэдээллийн менежмент муу байх, тусламжийн бараа материалын хангалт зохих хэмжээнд хүрч чадахгүй байх, ар талын хангалт дутагдах, аврах ажлын үед харилцан ажиллагааг муу зохицуулах, хүн амын дунд ухуулга сурталчилгааны ажлыг хангалтгүй явуулах зэрэг бэрхшээлтэй асуудлууд гарч ирж телевиз, радиогийн сурвалжлагч дийн анхаарлын төвд байдаг.

Аливаа онцгой нөхцөл байдлын үед хэвлэл мэдээллийн байгууллага/ телевиз нь мэдээллийг үр дүнтэй мэдээллийг дамжуулахын тулд доорхи арга хэмжээг хэрэгжүүлдэг.

- Гамшгийн аюул нүүрлэхээс өмнө орон нутгийн телевизийн студитэй харилцаа холбоо тогтоох;
- Бүх телевиз, мэдээллийн байгууллагууд нэг цагт, нэг ижил агуулгатай мэдээлэл цацах;
- Дараагийн удаа дамжуулах шинэ мэдээллийг дамжуулах цагийн хуваарийг сурвалжлагч нарт өгөх.
- Сурвалжлагч нарт мэдээгээ цуглуулж нэгтгэх боломж олгох үүднээс мэдээгээ бэлэн болох эцсийн цаг хугацааг харилцан тохиролцох. Энэ нь гамшгийн үед сурвалжлагч нарын хувьд нэвтрүүлэг цацагдах эцсийн

²² Ник Картер, Гамшгийн менежмент. УБ хот, 2006 он, х-241-242.

хугацаанаас өмнө үнэн зөв бодиттой мэдээлэл олж авч бэлтгэхэд тус болдог.²³

Онцгой байдлын албаны болон орон нутгийн захиргааны олон нийттэй харилцах албаны хүмүүс болон телевизийн мэдээллийн студи нь онцгой нөхцөл байдал үүссэн үед хамгийн түрүүнд найдвартай эх сурвалжаас үнэн зөв мэдээллийг олж авч хүн амд шуурхай дамжуулах гэсэн нэг зорилготой байх ёстой юм. 24 цагийн турш үйл ажиллагаа явуулдаг мэдээллийн агентлаг нь иргэд олон нийтийг тухайн үүсч буй асуудалд анхаарлыг төвлөрүүлэх гол арга зам бөгөөд бодит хэрэгцээтэй цаг мөчид аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар заавар удирдамж болж өгдөг. Сурвалжлагч өөрийн гэсэн хийх ажлын төлөвлөгөөтэй байдаг тул тэдэнтэй мэдээлэл хийх цагийг товлож өгөх хэрэгтэй. Мэдээлэл хийх цагийг товлосноор хүний амь насыг хамгаалах болон хэвлэл мэдээлэл, телевизийн студитэй нягт харилцан ажиллах нь тавьсан зорилтоо хэрэгжүүлэхэд тус болох болно.²⁴

Орон нутгийн радио телевиз, мэдээллийн хэрэгсэлтэй сайн холбоотой байх нь хоёр үндсэн ач холбогдолтой байдаг. Энэ нь зөвхөн гамшигтай тэмцэх удирдлагад үр ашигтай байх төдийгүй орон нутагт зарлан мэдээлэл дамжуулах нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хүн амын дунд ухуулга, сурталчилгааны ажил явуулахад үнэлж баршгүй ач холбогдолтой. Гамшгийн хор уршгийг арилгах ажлыг хүнд нөхцөлд гүйцэтгэх үед удирдлагаас мэдээллийн хэрэгслийг бусад албадаас доогуур түвшинд авч үздэг. Харин хэвлэл мэдээллийн ажилтнуудыг сайн зохион байгуулж ашиглаж чадвал бодит байдалд тийм биш байдаг байна.²⁵

Иймд гамшгийн үед дээрхи үйл ажиллагааны хүрээнд радио телевиз мэдээ, мэдээллийг сайтар бэлтгэн боловсруулж олон нийтэд шуурхай дамжуулах шаардлагатай юм.

“... Хэвлэл мэдээжүүлэлт нь гамшиг болон хямралт байдлыг субьектив загвараас нь харуулахыг чухалчилдаг. Магадгүй илэн далангүй сенсациас авахуулаад өөртөө тавих хяналт хүртэлх бүхий л арга замыг ашигладаг. Бодит байдалд яг юу болж байгаа болон шийдвэр гаргагч нар болон онцгой байдлын албаны хүмүүс, гамшигт нэрвэгдсэн хүмүүс болон олон нийтэд яг юу нөлөөлж байгаа зэргийн хоорондын ялгааг онцолсон хоёр туйл дахь нөхцөл байдлыг тодорхойлоход телевиз, радио чухал үүрэг гүйцэтгэдэг” (Rosenthal 1998, 157).

²³ https://emergency.cdc.gov/cerc/cerccorner/article_031517.asp

²⁴ Тэнд

²⁵ Тэнд

Тодорхой нөхцөлд телевиз радио нь төрийн захиргааны байгууллагаас гамшгаас хамгаалах талаар авч буй үйл ажиллагаанд ялангуяа иргэд олон нийтэд сэрэмжүүлэх мэдээ мэдээлэл дамжуулах, эрт зарлан мэдээлэх болон заавар, удирдамжаар хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн гамшгийн үед шийдвэр гаргагч нарыг хэрэгцээтэй мэдээллээр хангахад чухал үүрэгтэйгээр оролцдог.

Мөн телевиз радиогийн мэдээллийн байгууллагууд сөрөг үр дагавар хүргэж болох талтай байдаг. Тухайлбал, "...телевиз радио нь ихэвчлэн хэтэрхий бодит эх сурвалжгүй, хийрхэлийн шинж чанартай, нийтийг хамарсан дарамт, үймээн самуун бүхий гамшиг болон хямралт байдалд анхаарлаа хандуулах сонирхолтой байдаг." (Rosenthal 1998, 158). "телевиз радиогийн мэдээллийн байгууллагын давамгайлах хандлага нь гамшиг болон хямралт байдлыг улс төржүүлэхэд түлхэц өгдөг. Хэвлэл мэдээлэл нь гамшиг болон хямралт байдлын менежментийг улс төржүүлэх үйл явцыг хурдасгах нөлөөтэй.

Тэдгээр нь шийдвэр гаргагч нар болон хямралт байдлыг зохицуулах менежерүүдэд аюул гамшгаас хэрхэн урьдчилан сэргийлж зайлуулах эсвэл хямралт байдлыг таслан зогсоохын тулд авч буй арга хэмжээний талаар тайлбарлахад дарамт үзүүлдэг. Хямралт байдал бүрэн дуусах хүртэлх хугацаанд эрх баригчдыг олон нийтийн өмнө гарахаас татгалзахгүй байхын аргагүй хүнд байдалд оруулдаг. Үүний эсрэгээр, телевиз радио нь болзошгүй гай зовлон, авч буй арга хэмжээнд учирч буй алдаа дутагдал болон хууль эрх зүй, дүрэм журмын талаар улс төрийн албан тушаалтан, эрх баригчдаас хамгийн түрүүнд очиж асуулт асуухын төлөө өрсөлддөг. Хэрэв эрх баригчид олны өмнө мэдээлэл хийхэд эргэлзэж байгаа бол телевиз радиогийн сурвалжлагчид өөрсдийн асуултанд хариулах онцгой байдлын албаныхан, үйл явдлын гэрч, шинжээч гэх мэт хэн нэгнийг олж авдаг. Энэ нь тэдгээрийн улс төрийн байр суурийг бэхжүүлдэггүй. Гамшиг хямралт байдал нь өндөр дээд албаны хүмүүсийг санаатайгаар бууруутгах үйл явц руу хялбархан хувирч ордог ..." (Rosenthal 1998, 158)

Хүснэгт 2. Телевиз, радиогийн гамшгийн үеийн мэдээллийн эерэг ба сөрөг хандлага

Эерэг хандлага	Сөрөг хандлага
Гамшигт нэрвэгдсэн хүн амд мэдээлэл болон удирдамжаар хангах.	Хэтэрхий бодит эх сурвалжгүй, хийрхэлийн шинж чанартай, нийтийг хамарсан дарамт, үймээн самуун бүхий гамшиг болон хямралт байдалд анхаарлаа хандуулах сонирхолтой байдаг
Ирээдүйд тохиолдож болзошгүй бэлэн байдлын арга хэмжээний талаар мэдээллээр хангах.	Гамшиг болон хямралт байдлын менежментийг улс төржүүлэх үйл явцыг хурдасгах
Сайн дурын хөдөлгөөн болон цусны донорыг хандив тусламжийг хөхиүлэн дэмжих.	Шийдвэр гаргагч нар хямралт байдлыг таслан зогсоохын тулд авч буй арга хэмжээний талаар тайлбарлахад дарамт үзүүлдэг.
Засгийн газраас хариу арга хэмжээг эрчимжүүлэх хэрэгцээг олон нийтэд ил тод болгох.	Хямралт байдал бүрэн дуусах хүртэлх хугацаанд эрх баригчдыг олон нийтийн өмнө гарахаас татгалзахгүй байхын аргагүй хүнд байдалд оруулдаг
Сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй мэдээллийг түгээн дэлгэрүүлэхгүй байх.	Гамшиг хямралт байдал нь өндөр дээд албаны хүмүүсийг санаатайгаар бууруутгах үйл явц руу хялбархан хувирч ордог

Засгийн газрын бүх түвшинд төрийн албан хаагчид доорхи зүйлүүдийн төлөө хариуцлага хүлээх ёстой. Үүнд:

- Мэдээ мэдээлэл цуглуулагч нар нь онцгой нөхцөл байдлын үед ихэвчлэн шаардлагатай байдаг хүн хүч, материал хэрэгслийн нөөц болон цаг хугацааны тухай мэдээллийг шийдвэр гаргагч нар болон хариу арга хэмжээ авагч нараас байнга нэхэж байдаг.

- Тэдгээр нь энэхүү хандлагыг улам хэцүү нөхцөл байдал руу орох болоход хөндлөгөөс нөлөөлж эсвэл онцгой байдлын албаныхны ажлыг будлиулдаг.

- Телевиз радиогийн сурвалжлагчид гол төлөв өөр өнцгөөс тухайлбал, эсрэг эсвэл өдөөн хатгасан байр сууринаас ханддаг. Үүнийг улс төрийн сөрөг хүчнүүд бие биендээ шүүмжлэлтэй хандах, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хөндлөгөөс оролцохын тулд гудамжинд гарч цуглаан хийдэг гэж ойлгож болно.

- Хэвлэлийн эрх чөлөө гэдэг нэрийдлээр телевиз радиогийн сурвалжлагчид, хэвлэл мэдээллийнхэн аливаа цуу яриа дэгдээх эсвэл мэдээллийг амархан нуун дарагдуулсныхаа төлөө хариуцлага хүлээдэггүй. Учир нь засгийн газар үүнийг хийхийг хүсдэг. Сурвалжлагчид аливаа томоохон гамшгийн цар хүрээг тэр болгон бүхэлд нь хамарч сурвалжлага хийх нь ховор байдаг. Гамшгийн тухай телевизээр мэдээлж байгаа шиг ижилхэн зүйлүүдтэй онцгой байдлын албаны хүмүүс гол төлөв тулгардаггүй.

Гамшигтай тэмцэхэд “хэрэгцээтэй цагт хэрэгтэй мэдээлэл” шаардлагатай гэсэн зарчим түүхэн хугацаанд өөрчлөгдөөгүй байгаа болно.²⁶ Хүн амд гамшгаас урьдаж анхааруулж сэрэмжлүүлэх хэрэгтэй байдаг бол гамшгийн дараа хүний амь нас, эд хөрөнгөд учирсан эвдрэл хохирол, тэдгээрт үзүүлэх тусламж хангалт, хор уршгийг арилгах арга ажиллагааны талаарх өгөгдөл мэдээлэл шаардлагатай байдаг. Хүн амд гамшгаас хамгаалах боловсрол олгох болон эрт зарлан мэдээлэх дохиог шуурхай өргөн хүрээнд дамжуулснаар олон хүний амь насыг аварсан олон жишээ байдаг. Түүнчлэн телевиз радиогийн сурвалжлагчид нь иргэдийн гамшгийн тухай ойлголт мэдлэг олгох, аюулын тухай зарлан мэдээлэх, гамшигт нэрвэгдсэн бүс нутгийн тухай мэдээлэл цуглуулж дамжуулах, төр засгийн байгууллагууд, хүмүүнлэгийн тусламжийн байгууллагуудыг эрт зарлан мэдээлж бэлэн байдал оруулах, олон нийтийн тусгай хэрэгцээг тодорхойлох, гамшгийн бэлэн байдлыг хангах болон хариу арга хэмжээг зохион байгуулах талаар хэлэлцэхэд дэмжлэг үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Мөн телевиз радиогийн сурвалжлагчид нь гамшгийн аюул тулгарсан үед хэрхэн ажиллах талаар мэдлэгийг иргэд олон нийтэд олгоход хувь нэмэр болдог. Тухайлбал, зарлан мэдээллийг үр дүнтэй зохион байгуулах чухал үүрэгтэй байж болно. Гамшигт нэрвэгдэгсэд болон бусад хүмүүст зааварчилгаа болон сэрэмжлүүлэх мэдээллээр хангадаг. Түүнчлэн орон нутгийн гамшгийн хариу арга хэмжээг эрчимжүүлэхэд хувь нэмэр оруулдаг. Телевиз радиогийн сурвалжлагчид нь тухай бүрт асуудлуудын шалтгаан болдоггүй гэж болохгүй.

²⁶ Lankford, Darrell M. 1998. “Working with the Media During a Crisis.” NCCEM Bulletin 15.

Телевиз радиогийн сурвалжлагчид нь тэдгээрийн сониуч байдал болон хүмүүсийн санаа зовоосон бодит асуудал хоёрын давхцалыг ихэсгэхэд нэмээс болдог. Үр дүнтэй хариу арга хэмжээ авахад хөндлөгөөс нөлөөлөх байх гэж тооцож байсан телевиз радиогийн сурвалжлагчдийн хөндсөн асуудал нь онцгой байдлын албаныхны удирдлага зохицуулалтад дарамт үүсгэж болох талтай.

Мөн телевиз радиогийн сурвалжлагчид аливаа цуу яриа үүсгэх замаар гамшгийн бодит нөхцөл байдлыг гуйвуулж гамшгийн голомтоос хол байгаа гамшигт өртөөгүй хүмүүст гамшгийн хариу арга хэмжээний бодит байдлыг буруу ташаа мэдээлж болгох талтай. Зарим үед төр захиргааны байгууллагын удирдлага телевиз радиогийн сурвалжлагчдийг төвөгшөөдөг тал байдаг. Хэрэв телевизийн сурвалжлагчид төр захиргааныхны үйл ажиллагааг хянаж мэдээлэхгүй, гаргаж буй шийдвэрт ямар нэгэн асуулт тавихгүй, олон нийтийн дунд шүүмжлэлтэй уур амьсгал бий болгохгүй байх нь тэдгээрийг тайван нөхцөлд ажиллах боломжийг бий болгодог гэж үздэг. Гэхдээ гамшгийн үед телевиз радиогийн сурвалжлагч, хэвлэл мэдээллийнхэн тэнцвэртэй байдлыг хадгалах нь үнэн хэрэг дээрээ тус дэм болдог. Тэдгээрийн оролцоо мэдээлэлгүй бол олон хүндрэлтэй асуудлуудыг дагуулдаг. Түүнчлэн телевиз радиогийн сурвалжлагч, хэвлэл мэдээллийнхэн хувь хүмүүс, эсвэл албан байгууллагуудаас асуулт хариулт авах нь мэдээлэл олж авах арга зам нь болж өгдөг. Хэдийгээр телевиз радиогийн сурвалжлагч, хэвлэл мэдээллийнхэн иргэд олон нийтийн асуусан асуултад шууд хариулт өгөх боломжгүй ч гэсэн иргэд олон нийт болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагын удирдлагуудын хооронд холбох гүүр болж өгч чаддаг. Тухайлбал, гамшгийн үед хор уршгийг арилгах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах болон хүмүүнлэгийн тусламжийг дайчлахад телевизийн сурвалжлагч, хэвлэл мэдээллийнхэн ихээхэн тус нэмэр болж байсан олон жишээ байдаг. Төрийн албаны хүмүүс гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрхэн авч байгааг ойлгох нь хэвлэл мэдээллийнхний хамгийн чухал үүрэг байдаг. Шүүмжлэлтэй агуулга бүхий мэдээ тийм ч таа бус байдаг. Энэ нь хүний амь насыг аврах болон эд хөрөнгийг хамгаалах талаар өөрөөсөө шалтгаалах бүхнийг зориулан хүчин чармайлт гаргаж үйл ажиллагааг хэвлэл мэдээллийнхэн үнэн зөвөөр үзүүлж байгаа эсэхэд эргэлзэж байгаа Онцгой байдлын албаныхан болон хэвлэл мэдээллийнхэн хооронд үл ойлголцох байдалд хүргэдэг. Энэ нь гол төлөв хэвлэл мэдээллийнхний үйл ажиллагаанд саад болох үед гардаг.

Хэвлэл, мэдээллийн байгууллагууд гамшигтай тэмцэх байгууллагуудаас гамшгийн талаарх мэдээлэл авах тогтсон нийтлэг журам

байхгүйгээс хэвлэл, мэдээллийн байгууллагууд үйл явдлаас хоцрох, цаг хугацаа алдах байдал гардаг. (Ш.Болдбаатар, 1998, 41)

Шүүмжлэл бүхий мэдээлэл цацах нь улс төрчид болон төрийн албаныхныг аливаа алдаа дутагдал, буруу ажиллагааг судалж үйл ажиллагаагаа эрчимжүүлэх замаар хариу үйлдэл хийх нөхцлийг хангадаг. Үүнтэй нэгэн адил, хүнд хэцүү байдалд орсон гамшигт нэрвэгдэгсдийг телевизийн нэвтрүүлгээр үзсэн улс төрийн албан тушаалтнууд хариу үйлдэл авах нөхцлийг бүрдүүлдэг. Үндэсний хэмжээний нэвтрүүлэг цацах нь орон нутгийн эрх баригчдаас хүсэлт гаргаагүй байсан ч үндэсний болон улсын хэмжээний гамшигтай тэмцэх байгууллагын удирдлагууд хариу арга хэмжээ авахад хүргэдэг.

Хэдийгээр хариуцлагатай сэтгүүл зүйн хэм хэмжээнд дарамттай байх боловч ч гамшгийн үед аюултай байсан ч үйл явдлыг нэр даруй, яаралтай дамжуулах нь ихэнх сурвалжлагч нарыг зорилго байдаг. Зарим нэр хэвлэл мэдээллийнхэн олны анхаарал татахуйц эсвэл төрийн албаны дундах эсрэг байр суурь эсвэл тэдгээрийн хооронд болон бусад ашиг сонирхлуудыг сэргөлдүүлж өдөөн хатгасан мэдээг олж авахын төлөө байдаг. Үүнээс улбаалан, эрэн сурвалжилсан болон цуглуулсан мэдээллүүд нь онцгой байдлын албаны удирдлагад улс төрийн болон удирдлага зохион байгуулалтын хувьд хүндрэл учруулахуйц үр дагаварт хүргэж болно. Аливаа гамшгийн үед үйл явдлыг харуулсан видео бичлэгүүд хийгдэж, хувь хүний ашиг сонирхлыг харуулдаг ба тэдгээрт баатарлаг үйлстэн болон гол буруунуудын тухай байж болох талтай.

Төрийн албанынхан гамшгийн үед хүнд нөхцөл байдал орсон нэрвэгдэгсдийн төлөө хариу арга хэмжээ авах болон тэдгээрийг ойлгож санаа зовисон байдлаар хандах ёстой. Хэвлэлийнхэн энэхүү хариу үйлдлыг сурталчилах чухал ач холбогдол бүхий сувгаар хангадаг. Ихэнхи онцгой байдлын албаны байгууллагууд гамшгийн нөхцөл байдлын үед олон нийтэд гамшгийн мэдээллээр хангах чиг үүрэг бүхий олон нийтийн мэдээлэл хариуцсан ажилтан авч ажиллуулдаг. Тухайлбал, ОБЕГ –т Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэдэд тогтмол, шуурхай, цаг алдалгүй хүргэх, сэрэмжлүүлэх, албаны үйл ажиллагаа, онцлогийг олон нийтэд сурталчлах чиглэлээр төвийн 29 телевиз, 21 сонин, 35 цахим хуудас, 9 FM радио зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Дээрх хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран жилд дунджаар 1600 гаруй удаагийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж ажилладаг. Мөн байгалийн гамшиг, аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх тухай телевизийн 20-30 секундын сэрэмжлүүлэг

шторкийг жилд дунджаар 600 гаруй удаа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллаж байна.²⁷ “Аврагч” студи Гамшгийн эрсдэлийг бууруулах, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах дадал эзэмшүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын дэргэд “Аврагч” студийг байгуулжээ. “Аврагч” студийг түшиглэн гамшгаас урьдчилан сэргийлэх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, албаны үйл ажиллагаа, онцлогийг сурталчлах зорилгоор 14 хоног тутамд 15 минутаар “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийг бэлтгэн МҮОНТ-ийн 1, 2 дугаар суваг, UBS, Өлзий зэрэг телевизээр 2014 оноос эхлэн нийт 72 дугаар буюу 24 цагийн нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэн ажиллаж байна.²⁸

Гэхдээ Үндэсний олон нийтийн болон Орон нутгийн хэвлэл мэдээллийн анхаарч ажиллах зүйлүүд харилцан адилгүй байдаг. Үндэсний болон Орон нутгийн хэвлэл мэдээллийн анхаарч ажиллах зүйлүүдийг хүснэгт 1.4-т харуулав.

Хүснэгт 3. Үндэсний олон нийтийн болон Орон нутгийн хэвлэл мэдээллийн анхаарч ажиллах зүйлүүд

Түвшин	Үндэсний түвшин	Орон нутгийн түвшин
Анхаарах зүйлүүд	Гамшиг хямралт байдлын үед болон гамшгийн нэн дараах үе шатанд анхаарлаа хандуулах.	Гамшиг эсвэл ослын үр дагаварт анхаарлаа чиглүүлэх.
	Нэг бүрчилэн тодорхой зүйлүүдэд анхаарахаасаа илүү ерөнхий мэдээллээр хангах.	Үйл явцын тодорхой зүйл дээр төвлөрөх.
	Орон нутгийн хэвлэл мэдээллийнхнийг бодвол эрх баригчдаас илүү хүнд хэцүү асуулт асуух.	Нэрвэгдэгсдэд хандаж асуулт асуух
	Өдөөх чанарын мэдээлэл түгээх	Нөхцөл байдлыг намжаах тэсвэр тэвчээртэй байх
	Нэг загварын гамшигт үзэгдэл, араншингийн тухай тайлбарт итгэх.	
	Мэдээлэлд хяналт тавих эсвэл залуурдах оролдлого хийх.	

²⁷ Ш.Болдбаатар нар, Гамшгаас хамгаалах цагаан ном, УБ хот, 2017, х-40.

²⁸ Тэнд.

Гамшгийн үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулахдаа харьцан адилгүй онцлог талуудтай байдаг. Хүснэгт 1.5-д Гамшгийн үеийн мэдээллийг дамжуулах хэвлэл мэдээллийн хэрэгслийн харьцуулсан байдлыг харуулав.

Хүснэгт 4. Гамшгийн үеийн мэдээллийг дамжуулах хэвлэл мэдээллийн хэрэгслийн харьцуулсан байдал

Телевиз	Радио	Хэвлэл материал
Хүчтэй дүрс мэдээллийг эрэлхийх.	Богино хэмжээний мэдээ бэлтгэдэг.	Мэдээллийг хэвлэлийн байгууллагууд руу дамжуулахад факс болон интернетээс хамааралтай.
Богино хэмжээтэй дуу чимээ ашиглах, гамшгийн голомт болон нэрвэгдэгсдийг харуулдаг.	Цаг тухайд нь мэдээллийг хүргэхийг анхаардаг.	Телевиз эсвэл радиог бодвол цаг хугацаанд хязгаарлалт байхгүй бол олон төрөл янз байдаг.
Нэвтрүүлгийн хувиар болон цагаар нөлөөлдөг.	Гамшгийн мэдээллийг агаарын эфирээр эрх баригчдад хурдан хүргэх боломжтой тул эрт зарлан мэдээлэл дамжуулах үүрэг гүйцэтгэдэг.	Телевиз эсвэл радиог бодвол агуулгын хувьд илүү гүнзгий болон суурь мэдээллийг агуулдаг.
Мушгах гуйвуулсан буруу ташаа сурвалжлагыг худалдахад уруу татах.		Үйл явцын тухай бүртгэл мэдээллийн удаан хугацаагаар хадгалах боломжтой.

Гамшгийн үед радио телевиз, хэвлэл мэдээллийнхний ач холбогдол:

Радио телевиз хэвлэл мэдээллийнхний ач холбогдлыг тодорхойлох үндсэн хүчин зүйл бол тэдгээр нь гамшгийн нөхцөл байдал тохиолдохоос өмнө онцгой байдлын албаны удирдлагын бүлгийн бүрэлдэхүүн хэсэг байх явдал юм.

Тэдгээрийг гамшгаас хамгаалах төлөвлөлт болон дадлага сургуулилтад оролцуулах ёстой байдаг.

Хэрэв тэдгээр нь орон нутгийн оролцогч талууд болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар урьдаж мэдэж байх юм бол тэдгээрийн мэдээ нь илүү үнэн

зөв өргөн хүрээтэй мэдээллийг хамруулсан байх болно. Эрх баригч нар, Онцгой байдлын албаныхан болон олон нийт үнэн зөв, сайн үйл ажиллагаатай хэвлэл мэдээлэлтэй байхыг шаарддаг.

Хүснэгт 5. Онцгой байдлын албаныхан хэвлэл мэдээллийнхнээс юу хийхийг хүсдэг вэ?²⁹

Тэд юуг хүлээдэг вэ ?	Тэд гол төлөв юуг хүлээж авдаг вэ?
Хэвлэл мэдээллийнхэн уриалагхан түншлэгч байхыг хүсдэг	Хэвлэл мэдээллийнхэн хөндлөгийн ажиглагчийн байр сууринаас шүүмжлэлтэй ханддаг
Онцгой байдлын албаныхны үнэнч, тэдгээрийн өмнөөс хүчтэй дуу хоолой байхыг хүсдэг	Хэвлэл мэдээллийнхэн сонголттой байж тэдгээрийн мэдээллийг мушиган гуйвуулж дуу шуугиан тарьдаг.
Хэвлэл мэдээллийнхэн бодит үнэнд нягт нямбай хандаж байхыг хүсдэг	Хэвлэл мэдээллийнхэн өөрийн мэдээллийн “бодит байдлыг” бий болохыг зорьдог.
Хэвлэл мэдээллийнхэн аюул эрсдэлийн талаар нэгдсэн нэг төрлийн мэдээллийн болон хариуцаж буй төрийн албаны шугамаар заавар зөвлөмжийг дамжуулахыг хүсдэг	Хэвлэл мэдээллийнхэн аюул эрсдэлийн талаар өөр хоорондоо зөрчилдсөн мэдээллийг болон олон янзын мэдээллийг цөөн эх сурвалжаас заавар зөвлөмжийг дамжуулдаг.

Хэвлэл мэдээллийн үүргийг хямралт байдлын талаарх мэдээ мэдээллийг шинэчлэн боловсруулах болон зарлан мэдээлэх зэргээр эерэг талаас нь харахаас гадна худал буруу дүр зургийг дамжуулж хор уршгийг арилгах хариу арга хэмжээг мушгин гуйвуулах, үйл явдлыг дөвүүлгэн дэвэргэх зэрэг сөрөг үр дагавартай байдаг талаас нь харж болно.

Дүгнэлт

1. Монгол улсын хууль эрх зүйн болон удирдлагын баримт бичгүүдэд хэвлэл мэдээллийн байгууллага, телевиз, радиогийн гамшгийн үеийн үүрэг ач холбогдол, хязгаарлалтыг маш тодорхой зааж өгсөн нь тодорхой байна.
2. Телевиз радиогийн мэдээллийн нэвтрүүлэг нь олон нийтэд гамшгийн үеийн хэрэгцээтэй мэдээллийг гамшгийн менежментийн бүхий л үе шатанд

²⁹ <https://www.academia.edu>

- нь дамжуулж хүргэх суваг, арга зам болохоос гадна иргэд олон нийт гамшгийн талаарх мэдлэг, ойлголт олж авах гол хэрэгсэл болдог.
3. Телевизийн мэдээллийн нэвтрүүлгийн өмчийн хэлбэрээр олон нийтийн, хувийн, мэдээллийн түвшингээр орон даяар, орон нутгийн, мэдээллийн объектоор дотоод гадаад, мэдээллийн төрлөөр мэдээ, сурвалжлага, ярилцлага, теле сэтгүүл, бичлэгийн арга технологээр шууд сурвалжлага, шууд бичлэг, монтаж бичлэгийн гэж тус тус ангилагддаг.
 4. Гамшгаас хамгаалах талаар телевизийн мэдээллийн нэвтрүүлэг нь гамшгийн мөчлөгөөр гамшгийн өмнөх, гамшгийн үеийн, гамшгийн дараах гэсэн ангилалтай байж болно.
 5. Телевиз радиогийн гамшгийн үеийн үндсэн үүрэг нь гамшгийн нөхцөл байдлыг тодорхойлох явдал гэдэг нь маргаангүй юм. Дамжуулж буй мэдээний хувьд нэн даруй шийдвэрлэвэл зохих санаа зовоосон асуудал болон түүнд иргэдийн оролцоог хөхиүлэн дэмжихийг хамруулж телевизийн мэдээллээр үзүүлж харуулах нь магадгүй хамгийн чухал зүйл байж болох юм.

ЭХ СУРВАЛЖ

1. https://www.academia.edu/8070343/role_of_media_in_disaster_management
2. Ник Картер, Гамшгийн менежмент. УБ хот, 2006 он, х-241-242.
3. Ш.Болдбаатар нар, Гамшгаас хамгаалах цагаан ном, УБ хот, 2017, х-40.
4. Lankford, Darrell M. 1998. "Working with the Media During a Crisis." NCCEM Bulletin 15
5. https://emergency.cdc.gov/cerc/cerccorner/article_031517.asp